



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Байгууллагын нэр: ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: ЭРХ ЗҮЙ

Индекс: D042101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Мөнхбат

Гишүүд: Д.Наранчимэг

Б. Улаанбаатар

Улаанбаатар хот

2020

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн орчин

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

Оюутнуудын төлөөлөл

Ажил олгогчдын төлөөлөл

Төгсөгчдийн төлөөлөл

Ү. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
АГҮБ	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БЗД	Баянзүрх дүүрэг
БШУЯ	Боловсрол, Шинжлэх ухааны яам
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ИЗОУИС	Их Засаг олон улсын их сургууль
ИЗХЗС	Их Засаг Хууль зүйн сургууль
МХХ	Монголын хуульчдын холбоо
МУИС	Монгол Улсын их сургууль
ОХУ	Оросын холбооны улс
ОУИС	Олон улсын их сургууль
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
ХЗС	Хууль зүйн сургууль
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал

ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Их засаг олон улсын их сургууль Ikh zasag international University		
Сургалтын хөтөлбөрийн нэр	Эрх зүй Law		
Индекс	D042101		
Шинжээчид	<p>1. Ц.Мөнхбат / Монголын хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухааны Боловсролын хөгжлийг дэмжих хорооны дарга, БМИҮЗ-ийн Эрх зүйн мэргэжлийн зөвлөлийн гишүүн/</p> <p>2. Д.Наранчимэг /Отгонтэнгэр их сургуулийн ХЗС-ийн зөвлөх профессор, БМИҮЗ-ийн Эрх зүйн мэргэжлийн зөвлөлийн гишүүн/</p> <p>3. Б.Улаанбаатар /МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор/</p>		
БМИҮЗ-ийн зохицуулагч	П. Оргилмаа /БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн/		
Төлөвлөгөө, хэрэгжилт	Огноо	Хийгдсэн байх ажлууд	
	2020 оны 05 сарын 26	<p>1. Шинжээчийн баг ИЗОУИС-ийн ХЗС-ийн удирдлага, өөрийн үнэлгээний багтай уулзалт хийсэн. Шинжээч ажиллах хуваарь, хөндлөнгийн үнэлгээний талаар танилцуулав. ХЗС болон хөтөлбөрийн товч танилцуулгыг хийв.</p> <p>2. Хөтөлбөрт хамаарах материаллаг бааз /номын сан, лаборатори, төвүүд/-тай танилцсан.</p> <p>3. Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцаж нэмэлт тодруулга авсан.</p> <p>4. Өөрийн үнэлгээний багийнхантай уулзалт хийсэн.</p> <p>5. Хөтөлбөрт хамаарах багш, ажилтнуудтай уулзалт хийв.</p>	
	2020 оны 05 сарын 27	<p>1.Шинжээчдийн баг нотлох баримтуудтай танилцан, холбогдох багш, ажилтнуудаас нэмэлт тодруулга авсан.</p> <p>2.Оюутнуудтай цахим уулзалт хийсэн.</p> <p>3.Төгсөгчдийн төлөөлөлтэй цахим уулзалт хийсэн.</p> <p>4.Ажил олгогчдын төлөөлөлтэй цахим уулзалт хийсэн</p> <p>5.Нотлох баримтуудтай танилцан, тодруулга авсан.</p> <p>6.Шинжээчид үнэлгээний дүгнэлтээ нэгтгэж, хөтөлбөрийн удирдлага, өөрийн үнэлгээний багийнханд товч танилцуулав.</p>	
	Шалгуур шаардлага /журам/		БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Их засаг Хууль зүйн сургууль нь 1994 оноос эрх зүйч мэргэжлээр сургалт явуулж эхэлсэнээс хойш 2019 он хүртэл нийт 6539 эрх зүйчийг төгсгөсөн бөгөөд эрх зүйн бакалаврын боловсролын хөтөлбөрийн зорилго, зорилтыг Боловсролын тухай хууль /2002.05.03/, Дээд боловсролын тухай хууль /2002.05.03/, БШУ-ны сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс", БШУ-ны сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан "Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага", БШУ-ны сайдын 2014 оны 06-р сарын 27-ны өдрийн А/285 тоот тушаалаар батлагдсан "Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт", Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлөөс 2007 онд баталсан "Эрх зүйн боловсролын бакалаврын стандарт", ИЗОУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, "Их засаг олон улсын их сургуулийн дүрэм", "Дотоод журам", Их Засаг их сургуулийн 2009-2019 он хүртэлх мастер төлөвлөгөө, Оюутан суралцагчдад цогц боловсрол, өв тэгш хүмүүжил олгох нэгдсэн хөтөлбөр, "Супер студент" тэтгэлэгт хөтөлбөр, амжилт ахиулах хөтөлбөр зэрэг холбогдох баримт бичгүүдэд үндэслэн боловсруулсан бөгөөд эрх зүйн бакалаврын хөтөлбөрөө 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлж байна.

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

1. Их Засаг Хууль зүйн сургууль нь эрх зүйн хөтөлбөрийг боловсруулахдаа дараах бичиг баримт, тухайлбал,
 - "Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага", БШУС-ын 2014.04.28 тушаал А/174;
 - "Эрх зүйн боловсролын бакалаврын стандарт", Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007.10.10-ны өдрийн 36 тогтоол;
 - "Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур", БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018.06.26 тогтоол;
 - Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс, БШУС-ын 2014 оны тушаал, А/78;
 - Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт, БШУС-ын 2014.06.27 тушаал, А/285;

- Чингис хааны нэрэмжит ИЗОУИС-ийн дүрэм, Удирдах зөвлөлийн тогтоол А/05 2012.01.31;
 - ИЗОУИС-ийн Эрдмийн зөвлөлийн ажиллах журам, Ректорын тушаал А/237 2012.03.26;
 - Их Засаг ОУИС-ийн Сургалтын явцын төлөвлөгөө;
 - ИЗОУИС-ийн дүрэм журмын эмхтгэл, Амжилт ахиулах хөтөлбөр, УБ, 2017;
 - ИЗОУИСийн дүрэм журмын эмхтгэл, Чингис хааны нэрэмжит Их Засаг их сургуулийн оюутан суралцагчдад цогц боловсрол, өв тэгш хүмүүжил олгох нэгдсэн хөтөлбөр;
 - Сургалт, заах арга зүйн зөвлөл байгуулах, Ректорын тушаал А/39, 2019.05.31;
 - ИЗОУИС-ийн сургалтын журам, Ректорын тушаал А/187 2015.11.11;
 - ИЗОУИС-ийн багшийн ажлын үнэлгээний журам, Ректорын тушаал А/06 2017.10.20;
2. ИЗОУИС-ийн Лекц, семинарын хичээл явуулах болон оюутны мэдлэг, чадварыг дүгнэх заавар зэрэг баримт бичгүүдийг ашиглахаас гадна Их засаг ОУИС-ийн 2019-2025 он хүртэлх хөгжлийн мастер төлөвлөгөө баталсан байх ба Эрх зүй бакалаврын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр Их засаг ОУИС-ийн ректорын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дэд хороо 2015, 2016, 2018, 2019 онуудад 5 удаа, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртөө 2015, 2017, 2018, 2019 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулан нийгмийн хэрэгцээ, эрэлт шаардлага, харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр сургалтын төлөвлөгөөндөө сонгон судлах хичээл болон заавал судлах зарим хичээлийг сонгон оруулсан байна. Тухайлбал, Өв залгамжлалын эрх зүй, Хууль зүйн техник, арга зүй, Сонгуулийн эрх зүй г.м
3. Их засаг ОУИС нь Их засаг төгсөгчдийн холбоотой бөгөөд хамтарч ажилладаг байна. Энэ давуу талаа ашиглан ажил олгогч 12 байгууллага буюу ажил олгогчдоос төгсөгчдийнхөө талаар сэтгэл ханамжийн судалгааг 10 багц асуудлаар авч, төгсөгчдийн төлөөлөлтэй 25 жилийн ойн арга хэмжээний үеэр уулзаж ярилцан, хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр санал асуулга явуулж, үр дүнг хөтөлбөрийг шинэчлэх сайжруулахад харгалзан үзэж, 2019 оны 10 сард Эрдмийн зөвлөлийн хурлаар эрх зүйн бакалаврын хөтөлбөрөө шинэчлэн батлуулж, 2019-2020 оны хичээлийн жилээс мөрдөж эхэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Эрх зүйч мэргэжилтний загвар, орчин үеийн нийгмийн эрэлт хэрэгцээ, хууль зүйн салбарын шинэчлэлтэй уялдуулан эрх зүйн бакалаврын хөтөлбөрийн зорилгыг шинэчлэн сургалтын төлөвлөгөөнд шинэлэг хичээлүүдийг тусгасан байна.
- Их засаг Төгсөгчдийн холбоотой байнгын хамтын ажиллагаатай байна.
- Хөтөлбөрүүдийн зорилгод хийсэн харьцуулсан шинжилгээнд үндэслэн өөрийн сургуулийн хөтөлбөрийн онцлогийг тодорхойлсон ба сургалтын орчин үеийн чиг хандлага болох суралцагч төвтэй, судалгаанд суурилсан, судалгааны арга зүй, үр чадвар эзэмшүүлэх, суралцагчийг чадавхижуулахад чиглэсэн идэвхитэй сургалтын арга зүйг баримталсан байна.

Анхаарах асуудал:

- Гадаад орнуудын харьцуулсан судалгааг хийсэн боловч түүний үр дүнг хөтөлбөрт тодорхой тусгаагүй байна.

- Ижил мэргэжлийн хөтөлбөртэй сургуулиудаас өөрийн хөтөлбөрийн шинэчлэлийг гүнзгийрүүлэн өөрийн онцлогтой хөтөлбөр бий болгоход анхаарах.

Зөвлөмж:

Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан үндэслэл ерөнхий байдлаар байгаа бөгөөд дэлгэрүүлэн нарийвчлах шаардлагатай тул төгсөгчдөөс ирүүлсэн санал, хүсэлтийг ямар дарааллаар хүлээн авч хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгддэг байх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөр агуулга нь ХЗС-ийн болон хөтөлбөрийн зорилгодоо бүрэн нийцэж байна.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ суралцагч, ажил олгогч, төгсөгчдийн саналыг үндэслэдэг болох нь хөтөлбөрийн дэд хорооны хурлын тэмдэглэл, сэтгэл ханамжийн судалгааны материалаар нотлогдож байна.
- Хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлтийг хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудад мэдэгдэхээс гадна олон нийтэд вэбсайт, мэдээллийн хэрэслүүдээр ил тод болгодог нь хавсралт нотлох баримтаар нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Цогц боловсрол олгох хөтөлбөрийг сургалтын хөтөлбөртэй хослуулан хэрэгжүүлэхээс гадна онол болон практик мэдлэгийг хослуулан хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа болон клиник сургалтын төвийн үйл ажиллагаанд суралцагчдыг дагалдуулан, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, шүүхийн процесстой танилцуулах зэрэг нь онол практикийн мэдлэгтэй боловсон хүчин болж бэлтгэгдэн гарах, улмаар мэргэжлийн чадвар, дадал эзэмшүүлэхэд хөтөлбөрийн зорилго чиглэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад багш, хичээлээ сонгон судлах бололцоог илүү өргөн хүрээтэй олгодог байх;

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанар, үр дүн, ач холбогдол, онцлогийг бууруулахгүй байх;
- Хуульчийн ёс зүйг хэрхэн төлөвшүүлэх талаар зорилгодоо тусгах;

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй,

сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Эрх зүй бакалаврын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр Их засаг ОУИС-ийн ректорын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дэд хороо 2015, 2016, 2018, 2019 онуудад 5 удаа, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртөө 2015, 2017, 2018, 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан нийгмийн хэрэгцээ, эрэлт шаардлага, харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр сургалтын төлөвлөгөөндөө сонгон судлах хичээл болон заавал судлах зарим хичээлийг сонгож оруулсан байна. Эрх зүй бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэлэлцсэн нь хөтөлбөрийн дэд хорооны хуралдааны болон сургуулийн эрдмийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр нотлогдож байна. Мөн 2019 оны 09 сарын 11-ний өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар батлагдсан “Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт мэргэжлийн суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх болон сонгон чиглэлийн 57 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн, батлагдсан загварын дагуу боловсруулж, хөтөлбөрийн хорооны болон хөтөлбөрийн дэд хорооны хурлаар шат дараалан хэлэлцүүлж, Их засаг ОУИС-ийн ректороор батлуулан мөрдөж байна.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Клиник сургалтын төвийн үйл ажиллагаа нэлээн өргөн хүрээтэй явагддаг, тогтворжсон.
- Суралцагчийг цогц чадамжтай бие хүн болоход цогц боловсрол олгох хөтөлбөр давуу талтай байна.
- Онлайн сургалтыг хүндрэлгүй, цаг үед нийцсэн байдлаар зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- Эрх зүйн хөтөлбөрөөр суралцаж байгаа суралцагч болон хичээл зааж буй багш нарын хэлний мэдлэгт анхаарах, хэлний сургалтанд багш суралцагчийг өргөн хүрээнд хамруулах;
- Оюутан багаар ажиллах орчинд илүү анхаарах;

Зөвлөмж

- Төгсөлтийн дараах ахисан түвшний болон давтан сургалтын цар хүрээг улам нэмэгдүүлэх;
- Онлайн сургалтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар бусад ижил мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулиудад туршлагаасаа хуваалцах;

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: *БҮРЭН ХАНГАСАН*

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсрол, Шинжлэх ухааны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, “Их засаг” ОУИС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэрт үндэслэн, хөтөлбөрийн зорилго, зорилгод нийцүүлэн “Их засаг” Олон Улсын Их Сургуулийн ректорын 2019 оны 5 сарын 10-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлан мөрдөж байна.
- ИЗХЗС-ийн бакалаврын сургалтын нэгдсэн төлөвлөгөө нь Монгол Улсын Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 10 сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан MNS 5323-39:2007 стандарт, 2011 оны 4 сарын 28-ны өдрийн “Үндэсний стандартад нэмэлт өөрчлөлт оруулах, дахин хянаж шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоол, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-д заасан агуулгад нийцсэн байна.
- ИЗХЗС-ийн “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-н дэх ерөнхий суурь 18 хичээлийн 38 багц цаг, мэргэжлийн суурь 15 хичээлийн 32 багц цаг, мэргэжлийн 35 хичээлийн 58 багц цаг, нийт 128 багц цаг нь Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын 2.2.1-д заасан “Бакалаврын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь 120 багц цагаас доошгүй байх” шаардлагыг хангаж байна.
- Эрх зүйн хөтөлбөрөөр суралцагсдад цогц чадамжийг олгоход чиглэсэн агуулгыг хичээл тус бүрийн хөтөлбөрт тусгасны зэрэгцээ оюутны мэдлэг чадварыг үнэлэх орц гарцын үнэлгээг нарийвчлан зохицуулсан байна
- Сургалтын төлөвлөгөөгөөр нэг оюутанд 7 хоногт ногдох цагийн ачаалал 19 академик цаг байгаа нь оюутан өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах, чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх боломжтой болохыг гэрчилж байна.

Шалгуурыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулахдаа сонирхлын бүлгүүдээс авсан судалгааг харгалзан ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхэд анхаарсан байна.

- Долоо хоногийн нэг өдрийг оюутны бие даах өдөр болгосон бөгөөд энэ өдөр багш нар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх боломжтой болжээ.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийг гадаад, дотоодын их, дээд сургуулиудын эрх зүйн бакалаврын хөтөлбөртэй харьцуулан судалж дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сургуулийн хөтөлбөрийн хороо, ба эрх зүй мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан “ерөнхий болон мэргэжлийн суурь (нийт 33 хичээл)”, “мэргэжлийн (35) хичээл”-ийн тоо, төрөл, багц цагийн зохистой харьцааг хангахад цаашид анхаарах;
- Бакалаврын түвшинд суралцдаг олон оюутантай тул танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын нэг оюутанд оногдох хүртээмжийн тооцоо судалгааг гарган, дүгнэлт хийх;

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөн дэх мэргэжлийн хичээлийн тоо, төрөл, багц цагийг нэмэгдүүлэн, ерөнхий болон мэргэжлийн суурь зарим хичээл (Монголын түүх, соёл, ёс заншил”, “Монголын төр, эрх зүйн түүх”, “Их засаг судлал” гэх мэт)-ийн давхардлыг арилган, эрх зүй хөтөлбөрөөр суралцагсдад “Цэргийн хэргийн эрдэм”, “Цагдаагийн эрх зүй” зэрэг “их сургуулийн түвшин”-д кредит цагт тооцуулан судлах хичээлээс хасах замаар “ерөнхий болон мэргэжлийн суурь” хичээлийн төрлийг илүү оновчтой тогтоож, мэргэжлийн суурь хичээлийн тоо болон багц цагийг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.
- Сургалтын төлөвлөгөөн дэх мэргэжлийн хичээлийг “заавал судлах” болон “сонгон судлах” гэсэн хоёр төрөлд ангилж оюутанд сонирхсон чиглэлийн хичээлийг сонгон түлхүү судлах боломж олгох ач холбогдолтой.
- Сургалтын үйл ажиллагаа (багшийн сургалт, эрдэм шинжилгээ, олон нийтийн үйлчилгээ, оюутны суралцах үйл ажиллагаа)-нд кредит (багц) цагийн системийг бүрэн нэвтрүүлэх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗХЗС-ийн D042101 индекстэй эрх зүйн бакалаврын хөтөлбөрийн дөрөвдүгээр хэсэгт “Сургалтын арга зүй”-н үндсэн асуудлыг тусгайлан оруулсан байна.
- Сургалтын арга зүй нь багшийн сургах арга, оюутны сурах үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд оюутан төвтэй, оюутны оролцоонд түшиглэсэн байна.
- Сургалт нь S-Student centered-оюутан төвтэй, P- Problem based-ацуултад суурилсан, I-Integrated оюутны оролцоонд түшиглэсэн, C-Community based-амьдралд ойр дөт байх, S-Systematic-зохион байгуулалттай байх гэсэн шаардлагаас бүрдэх “SPICES” зарчмаар явагдахаар сургалтын хөтөлбөрт тусгагдсан байна.

- Оюутны хүлээх үр дүн нь цөм хөтөлбөр, заах, суралцах, үнэлэх, дүгнэх үйл явцын нийлбэрээр тодорхойлогдоно.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Вертуал болон IZIUTV цахим номын сан, XCLOUD программ ашигладгаас гадна Interactive program, Facebook-ийг сургалтын үйл ажиллагаанд ашигладаг.
- ИЗХЗС-ийн эрх зүйн хөтөлбөрийн багш Л.Эрдэнэхүү “Захиргааны эрх зүйн хичээлийн гар утасны application”-г 2019 онд зохиож, сургалтад нэвтрүүлсэн бөгөөд багш оюутны бие бие рүү чиглэсэн сургалтын бүх төрлийн үйл ажиллагаа (тухайлбал, тестээр шалгалт авч автоматаар дүгнэх)-г явуулах боломжтой юм.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчийн хүсэл сонирхолд нийцэх, эрх зүйч боловсон хүчний эзэмшвэл зохих цогц чадамжийг тодорхойлон, уг зорилгод хүрэхийн тулд сургалтын олон төрлийн арга зүйг ашиглахаас илүүтэй ямар хичээлд ямар төрлийн сургалтын арга зүй нь илүү тохиромжтой болохыг судалж тогтоон, сургалтад нэвтрүүлэх.

Зөвлөмж:

- Мэргэжлийн дадал, чадвар эзэмшүүлэх шаардлагатай дадлага хичээлийн тоо, төрөл, багц цагийг нэмэгдүүлэх чиглэлийг цаашид тууштай баримталж, тохиолдол, кейс шинжлэх хэлбэрийг семинарын хичээлд ашиглаж, бодлого бодох (кейс шинжлэх) аргачлалыг оюутанд эзэмшүүлэхэд онцгойлон анхаарах;
- Оюутан хичээл болон багшаа чөлөөтэй сонгох боломжийг нэмэгдүүлэх;

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн мэдлэг, чадварыг ИЗОУИС-ийн Ректорын 2015 оны 11 сарын 11-ний өдрийн А/187 тушаалаар батлагдсан сургалтын журам, ИЗОУИС-ийн лекц, семинарын хичээл явуулах болон оюутны мэдлэг, чадварыг дүгнэх заавар, Шалгалтын явцыг хянах, дүгнэх журам, Шалгалтын үнэлгээтэй холбоотой гомдлыг барагдуулах журам, Шалгалтаас хоцорсон оюутны асуудлыг шийдвэрлэх журам, Хөгжлийн бэрхшээлтэй оюутны үнэлгээнд шударга хандах заавраар тус тус үнэлдэг байна.
- Оюутны мэдлэг чадварыг Блүүмийн таксономи болон рубрикийн аргаар үнэлж оюутны ахиц дэвшлийг тодорхойлдог байна.
- Суралцагчийг үнэлэх үнэлгээний зорилт нь оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд орших бөгөөд 100 онооны системээр дүгнэнэ.
- Шалгалттай хичээлийн улирлын шалгалтыг 30, суурийг 70 оноогоор үнэлэхдээ улирал дундын шалгалтыг 24 хүртэл, бие даалтыг 10 хүртэл, лекц, семинарын ирц, товчлол, тэмдэглэлийг 12 хүртэл, семинарын хичээлийн ирцийн идэвхийг 24 хүртэл оноогоор дүгнэдэг байна.

- Явцаар дүгнэх хичээлийн мэдлэг, чадварыг үнэлэхдээ улирал дундын шалгалт 24 хүртэл, бие даалт 20 хүртэл, семинарын идэвхи 24 хүртэл, лекц, семинарын ирц 20 хүртэл, лекц, семинарын товчлол, тэмдэглэл 12 хүртэл оноогоор дүгнэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөгжлийн бэрхшээлтэй оюутны үнэлгээнд шударга хандах зааврыг баталж мөрдүүлдэг.

Анхаарах асуудал:

- Сурлагын амжилт, чанарыг бодитойгоор тогтооход оюутныг үнэлэх аргачлал нь нийцэж буй эсэхийг анхаарах;

Зөвлөмж:

- Оюутны мэдлэгийг үнэлэх үнэлгээний аргачлал (улирлын шалгалт 30 оноо, суурь 70 оноо)-ыг тогтооход баримталсан зарчим болон оюутны мэдлэг, чадварыг бодитойгоор үнэлж чадаж буй эсэхэд дүгнэлт хийж цаашид улам боловсронгуй болгох.

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗХЗС нь 1918,7 метр квадрат талбай бүхий 5 давхар нэг хичээлийн байранд сургалтын үйл ажиллагаа явуулахаас гадна ИЗОУИС-ийн төв байранд байрлах 409,5 м/кв талбай бүхий нэг лекцийн танхим, 4 анги, 2 компьютерийн лаборатори, ИЗХЗС-ийн хичээлийн II байранд нэг лекцийн танхим, 8 анги, спорт зааланд үйл ажиллагаа явуулдаг.
- ИЗХЗС-ийн IV давхарт оюутны бие даалтын өрөө, оюутан үйлчилгээний төв, клиник сургалтын төв, цэргийн хэргийн эрдмийн танхим, багш нар амрах зориулалттай өрөө нь ИЗХЗС-ийн I, II-р байрны B1, 1, 2, 3-р давхарт, ИЗОУИС-ийн төв байранд Инноваци хөгжлийн төвд шүүх хуралдаан болон криминалистикийн танхимтай.
- ИЗХЗС-ийн хичээлийн байрны бүх давхарт эрэгтэй, эмэгтэй хүний ариун цэврийн тусдаа өрөөтэй, оюутанд зориулсан кафе, канон, хувцасны өлгүүр, хувцас солих өрөө, тасалгаа, хувцасны шүүгээтэй.
- ИЗОУИС-ийн нийт орлогын төсвийн 42 орчим ИЗХЗС-ийн орлого бүрдүүлдэг бөгөөд ИЗХЗС-ийн төсвийн гүйцэтгэлээс дүгнэхэд жилийн нийт орлогын 5.6 орчим хувийг эрдэм шинжилгээ, судалгаа болон багш, оюутныг хөгжүүлэхэд зарцуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн байрны нийт талбай 4273,4 м/кв бөгөөд нэг суралцагчид ногдох улсын стандарт 1.3 м/кв, ИЗХЗС-ийн нэг оюутанд ногдож буй талбайн хэмжээ 2.1 м/кв байгаа нь улсын стандарт хэмжээнээс 0,8 м²-аар илүү байна.
- Оюутны суралцах таатай орчныг бүрдүүлсэн.
- Шүүх хуралдааны болон криминалистикийн танхим, спорт заалтай.
- Мэргэжлийн хичээлийг заадаг багш нар тухайн хичээлийн хэрэглэгдэхүүн (шаардлагатай зарим ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүл, зөөврийн болон суурин компьютер, проектор, CD, хичээлийн агуулгыг харуулсан үзүүлэн, самбар, курсын болон бакалаврын ажил)-ээр тусгайлан тохижуулсан өөрийн анги танхимтай байх бөгөөд уг танхимдаа хичээлээ заадаг.

Анхаарах асуудал:

- Анги, бүлгийн зохион байгуулалттайгаар лекц, семинарийн хичээл явагддаг тул нэг оюутанд оногдох талбай хэдийгээр их байдаг ч ангиудад хичээллэх оюутны тоо их байдаг тул танхимд суух оюутны тоог багасгах замаар нэг оюутанд оногдох талбайг нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Бодлого, тохиолдол, кейс шинжлэх семинарын хичээлийн оюутны тоог 15- аас дээш гаргахгүй байх тохиолдолд нэг оюутанд хүртэх хүртээмж боломжтойд тооцогддог тул семинарын хичээлд дунджаар 30-35 оюутан сууж байгааг багасгах;
- Зөөврийн компьютер, проекторыг зарим анги танхимд зөөвөрлөн аваачиж, хичээл, сургалтад ашигладгаас зайлсхийж, суурин PC компьютер, проектор суурилуулж сургалт явуулах нөхцөл, боломжоор хангах;

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

- Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗХЗС-ийн суралцагчид болон багшийн сургалтын үйл ажиллагаанд лекц, семинарын хичээлийн нэмэлт гарын авлага, танилцуулга, хичээлийн хуваарь, хөтөлбөр, төлөвлөгөө, суралцагчийн дүнгийн тодорхойлолт, сорилын тест зэргийг багтаасан Xcloud программыг тусгай зөвшөөрөлтэйгөөр сүүлийн 3 жил ашиглаж байна.
- Сургалтын гол хэрэглэгдэхүүн болох номын сангийн үйлчилгээнд олон улсын номын сангийн UNIMARC, MARC21 стандарттай Коха программыг ашигладаг.
- Сургалтын ажлыг зохион байгуулах харилцааг зохицуулсан ИЗОУИС-ийн Сургалтын журам, Шалгалтын явцыг хянах, дүгнэх журам зэрэг 20 гаруй дүрэм, журам, заавар хэрэгжиж байна.
- Сургалтын чанар, үр дүнгийн ахиц, дэвшлийг сайжруулах зорилгоор E-контент хэлбэрээр боловсруулсан Power Point, audio, video байдлаар бэлтгэсэн лекц, семинарын хичээлд ашиглах хэрэглэгдэхүүн, цахим хичээл, подкаст хичээл, цахим тест, CD зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж байгаа бөгөөд 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн E-контент хэлбэрээр боловсруулсан хичээлийн

хэрэглэгдэхүүний хувь тасралтгүй өссөөр 2019-2020 оны хичээлийн жилд 100 хувь болж өссөн.

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- Е контент хэлбэрээр боловсруулсан цахим сургалтын материаллаг баазыг 100 хувьд хүргэж ашигладаг.

Анхаарах асуудал:

- Сургуулийн зүгээс сургалтын үйл ажиллагаанд нэн тэргүүнд хэрэгцээтэй PC компьютер, проектороор анги, танхимыг бүрэн хангахад анхаарах;

Зөвлөмж:

- Сургалтад хэрэглэгдэх материаллаг нөөцөөс гадна сургалтын гол хэрэглэгдэхүүн болох багшийн заах хичээлийн хөтөлбөр дэх сэдэв, агуулгын дагуу бичигдсэн конспект, тест, бүрэн бодолт бүхий кейсийн санг чанаржуулах, тогтмол баяжуулах;

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗХЗС нь Уншлага-1 номын сан, төв номын сан, эрдэм шинжилгээний номын сантай.
- ИЗОУИС-ийн номын сан нийт 18721 нэр төрлийн 68842 ширхэг ном, сурах бичигтэй бөгөөд электрон хэлбэртэй 600 гаруй ном, сурах бичигтэй, үүний 10000 нь хууль зүйн мэргэжлийн ном, сурах бичиг ба номын фондын эргэлт 90.5 хувь, нэг оюутанд 8-9 ном, сурах бичиг гарын авлага ногдож байна.
- Сүүлийн 5 жилд 1123 нэр төрлийн 4295 ном, сурах бичиг, гарын авлагаар номын фондыг баяжуулсан.
- ИЗХЗС ном, сурах бичиг худалдан авах, хэвлүүлэхэд 2016-2017 оны хичээлийн жилд 10 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэл 10 сая 800 мянган төгрөг, 2017-2018 оны хичээлийн жилд 20 сая төгрөг төсөвлөснөөс 21 сая 16 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 2018-2019 оны хичээлийн жилд 25 сая төгрөг төсөвлөснөөс 27 сая 354 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байх бөгөөд нийт 4 сая 171 мянган төгрөгийн гүйцэтгэлийн хэтрэлттэй байна. (ИЗХЗС-ийн “Эрдэм шинжилгээ судалгаа болон багш, оюутныг хөгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө” санхүүгийн баримтад тулгуурлав)

Шалгуурыг хангасан байдал: *Бүрэн хангасан*

Онцлог зүйл/Туршлага:

- ИЗХЗС хичээлийн байрандаа хоёр номын сантай бөгөөд 150 суудал бүхий нэг уншлагын танхимтай, 24 цагаар ажиллахаас гадна ИЗОУИС-ийн төв номын сангаар оюутан үйлчлүүлэх боломжтой.
- Оюутны дотуур байранд 24 цагаар ажилладаг номын сантай бөгөөд хичээлийн байран дахь номын сангаас ном захиалан авах боломжоор хангагдсан.

Анхаарах асуудал:

- Номын сангийн фондод хадгалагдаж байгаа ном, сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сэтгүүлийн ашиглалтыг нэмэгдүүлэхэд анхаарах;

Зөвлөмж:

- Сургалт, эрдэм шинжилгээнд ашиглагдах, гадаад хэл дээрх мэргэжлийн ном сурах бичиг, сэтгүүлийн нэр, төрлийг олшруулах;
- Хууль зүйн шинжлэх ухааны тодорхой чиглэлээр дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачдын туурвисан нэг сэдэвт бүтээл болон ном, сурах бичиг, гарын авлага, мөн эрдэм шинжилгээний сэтгүүлийн хүрэлцээ, төрөл, тоо, эзлэх хувь хэмжээний судалгааг тогтмол гаргаж, түүнд үндэслэн номын сангийн баяжуулалтыг хийж байх;

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтынүйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг тодорхой болгох, ажил үүргийн хуваарийг тогтоох, сургалтын чанарыг улам сайжруулах зорилгоор сургуулийн дотоод дүрэмд заасны дагуу хөтөлбөрийн хороо, профессорын баг, хөтөлбөрийн дэд хороог ректорын тушаалаар байгуулсан ба эрх зүйн хөтөлбөрийн дэд хороо нь Их засаг Хууль зүйн сургуулийн дэргэд ажилладаг ба Хөтөлбөрийн дэд хороог хөтөлбөрийн удирдагч ахалдаг. Хөтөлбөрийн баг нь эрх зүйн хөтөлбөрийн сургалтыг явуулах, сургалтын чанар үр өгөөжийг ахиулах, шаардлагатай бичиг баримтуудыг нарийн төлөвлөж боловсруулах, багш нарынхаа ур чадварыг сайжруулах зэрэг үндсэн үүрэгтэй. Хичээлийн хөтөлбөрүүдийг эрх зүйн хөтөлбөрт, эрх зүйн хөтөлбөрийг сургуулийн эрхэм зорилго, зорилт, бодлого, төлөвлөлт болон эрх зүйч мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилттой уялдуулан боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах замаар шинэчлэн боловсруулдаг байна.
2. ИЗОУИС-ийн дэргэд профессорын баг ажиллах ба Ректорын тушаалаар томилон сургалтын үйл ажиллагааг сайжруулахад дэмжин тусалж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгдөг үр дүнтэй байна. Тухайн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцүүлэн баталж хичээл сургалтыг үйл ажиллагааг явуулж семистр тус бүр хөтөлбөрийн удирдагч ажлаа тайлагнадаг.
3. ИЗХЗС-ийн сургалтын орчны хувьд тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдсэн байна. Мөн улирал бүр багш, оюутнаас

социологийн болон сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнд анализ хийн сургалтын үйл ажиллагааг сайжруулахад тогтмол ажиллаж иржээ.

4. Эрх зүйн хөтөлбөр нь “Үр дүнд суурилсан буюу CDIO” хөтөлбөрийг бүрэн тусгасан төдийгүй БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалд заасан Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг хангасан, Цогц боловсрол олгох хөтөлбөрийг хичээл тус бүрээр хэрэгжүүлдэг. Мөн оюутны мэдлэг чадварыг үнэлж дүгнэхдээ Блүүмийн таксономи болон рубрикийн аргаар үнэлж оюутны ахиц дэвшлийг тодорхойлон үнэлдэг байна. Сургалт явуулах орчин үеийн үр дүнд суурилсан үр өгөөжтэй арга хэлбэрүүдийг багш бүр сургалтандаа нээлттэй хэлбэрээр хэрэгжүүлж харилцан туршлага солилцдог нь давуу тал болж байна.
5. Тухайн хөтөлбөрөөр суралцагч нь өөрийн санал хүсэлт, шүүмж, гомдол чөлөөтэй гаргаж шийдвэрлүүлэх бололцоогоор бүрэн хангагдсан байна. Тухайлбал, Суралцагчаас ирж буй санал, гомдлыг санал хүсэлтийн хайрцгаар болон цахим хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэдэг байна. Хэлбэрийн хувьд:
 - Бичгээр буюу өргөдлөөр сургуулийн удирдлагын багт хандах;
 - Ганцаарчлан уулзах;
 - Сэтгэл ханамжийн судалгаагаар тодорхой бичих боломжтой;
 - Фэйсбүүк группүүдээр илэрхийлэх;
 - Сургуулийн веб сайтаар дамжуулан сургуулийн захиргаанд хандаж болно г.м олон шугамаар өөрийн санал бодлоо илэрхийлж болдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ИЗХЗС-ийн сургалтын үйл ажиллагааг ИЗОУИС-ийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн тухайн жилийн ИЗОУИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2019-2025 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөөг мөрдлөг болгон ажилладаг байна.
- Эрх зүйн хөтөлбөр нь “Үр дүнд суурилсан буюу CDIO” хөтөлбөрийг бүрэн тусгасан төдийгүй БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалд заасан Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг хангасан, Цогц боловсрол олгох хөтөлбөрийг хичээл тус бүрээр хэрэгжүүлдэг

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн удирдлагын зохион байгуулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх;

Зөвлөмж:

Хөтөлбөрийн удирдлагын зохион байгуулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэхдээ олон талт хамтын ажилагааг хөгжүүлэх;

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

Дараах төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлсэн буюу зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд

- БНСУ-ын Дегү их сургуультай хамтран хэрэгжүүлсэн “Үйлдвэрлэл-их сургуулийн манлайлагчдын хамтын ажиллагаа” төсөл;
- БНСУ-ын Куин-Ин Эмэгтэйчүүдийн Их Сургуультай (КИЭИС) хамтран хэрэгжүүлсэн соёл хоорондын “Life Lesson” төсөл;
- ОХУ-ын Буриадын Улсын Их Сургуультай хамтран “XVII-XXI зууны Орос-Монгол-Хятад: хил дамнасан харилцааны түүхэн туршлага ба хэтийн төлөв” төсөл (2018; төслийн хөрөнгө – 800.000 RUB);
- ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Сибирийн салбар, Монгол, Түвд, Будда Судлалын Хүрээлэнтэй хамтарсан хүмүүнлэгийн суурь судалгааны төсөл 2018; төслийн хөрөнгө – 800.000 RUB);
- 2019 оны 4 сард БНСУ-ын Канвоны их сургуулийн хуулийн сургуультай хамтран “Монгол Солонгос улсын эрх зүйн тогтолцоо ЭШХ г.м

Их засаг Хууль зүйн сургууль дараах ажил үйлчилгээг эрхлэн нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн байна. Үүнд:

- Хууль зүйн клиник сургалтын төв;
- Рояль телевизтэй хамтран “ТВ- өмгөөлөгч” нэвтрүүлгийг тогтмол явуулж иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч ажилладаг;
- Өмгөөлөгч багш нарын ажил үйлчилгээ;
- “Оюутан-Эргүүл” арга хэмжээ;
- Сайн үйлсийн аян өрнүүлэх зэрэг ба тодруулж үзвэл,

“Хууль зүйн клиник сургалтын төв” нь 2007 онд анх байгуулагдан дадлагын сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүргийг гүйцэтгэж байна. Клиник сургалтын төв нь ОХУ-ын Эрхүүгийн их сургуультай 2007 оноос эхлэн хамтран ажиллаж 2 жилд нэг удаа хууль зүйн зуны сургалтыг эх орондоо болон ОХУ-д ээлжлэн зохион байгуулах хэлбэрээр оюутнуудаа хамруулан туршлага судлан ажиллажээ.

Эрх зүйн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг улам бүр нэмэгдүүлэх, онол-практикийн нэгдлийг хангах зорилгоор оюутнуудыг байгууллагуудтай гэрээ хийсний үндсэн дээр танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг нь хийлгэдэг байна.

Их засаг төгсөгчдийн холбоо нь ИЗХЗС-тай байнгын хамтын ажиллагаатай байдаг бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Төгсөгчдийн судалгаа, Сургуультай хамтран зохион байгуулах үйл ажиллагаа, Их засаг Төгсөгчдийн холбооны чуулга уулзалт, Төгсөгчид суралцаж байгаа оюутнууддаа мэргэжлийн дадлага олгох сургалт, семинар лекц зохион байгуулах, эрдэм шинжилгээний илтгэл бичих, илтгэх, мэтгэлцэх ур чадварын сургалтуудыг хамтран зохион байгуулж байна. Мөн Их Засаг ОУИС төгсөгчдийн мэдээллийг нэгтгэн гарын авлага гаргасан байна. Их засаг төгсөгчдийн холбоо нь брэнд бүүк, Их засагчуудыг нийгэмд гүйцэтгэх үүрэг, манлайлал зэрэг хэлэлцүүлгийг уламжлал болгон зохион байгуулж байгаагаас ажлын байрны нээлттэй хаалганы өдөрлөгийг сургуультай хамтран тогтмол зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Их Засаг ОУИС нь ОХУ, БНХАУ, АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, Их Британи, Австрали, Турк, Кипр, Сингапур, Филиппин, Малайз зэрэг орны 50 гаруй их, дээд сургууль, байгууллагатай багш, оюутан солилцох, 1+3, 2+2, 1+1 гэсэн бакалавр, магистрын болон сертификатын сургалт, судалгаа, шинжилгээний төслүүд хэрэгжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, харилцан туршлага солилцох зэрэг олон хэлбэрээр хамтран ажиллаж байна. Мөн БНСУ-ын Канвоны Үндэсний Их Сургууль, Тэгүгийн Их Сургууль, Алс Дорнодын Их Сургууль, Кён-Ин Эмэгтэйчүүдийн Их Сургууль, Японы Киото-Гакуэн-ий Их Сургууль, Комазава-гийн Их Сургууль, БНХАУ-ын Хэбэйн Их Сургууль, БНХАУ-ын Өвөр Монголын Багшийн Их Сургууль, Тянжиний Аж Үйлдвэрийн Их Сургууль, Киприйн Каса Коллеж зэрэг сургуулиудтай багш, оюутан солилцооны хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Мөн Японы Юкай Резорт компанитай байгуулсан гэрээний дагуу тус их сургуулийн 32 оюутан Японд 1 жилийн хугацаагаар цалинтай дадлага хийж байна.

Анхаарах асуудал:

- Цаашид дээрх ажлуудаа улам сайжруулж сургалтын ажилтай уялдуулах;

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны нөөц бололцоо үр нөлөөг илүү ашиглан, хамтран ажиллах;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо: Дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн гол эх үүсвэр болох боловсролын зээлийн сангаар олгож байсан үндэсний тэтгэлэг /2015, 2016/ болон оюутны хөгжлийн зээл /2017 оноос хойш/, гадаад, дотоодод суралцагчдын сургалтын төлбөр, тогтмол зардлаас бүрдэж байна.

Хүснэгт. Төрөөс боловсролын салбар болон дээд боловсролд зарцуулж буй зардал

Зардал	2015 он	2016 он	2017 он	2018 он
Боловсролын салбарт /сая төгрөгөөр/	978.5	1147.6	1112.2	1305.8
Дээд боловсролын салбарт /тэрбум төгрөг/	88.6	158.1	95.3	123.6
Дээд боловсролын салбарт /хувь/	9.1	13.8	8.6	9.4

ИЗОУИС-ийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөр, үүрэг тэдгээртэй холбогдсон, түүнд шаардагдах эх үүсвэр, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц болох төсвийг төлөвлөх, батлах хэрэгжүүлэх, тайлагнахад:

- ✓ Төсвийн тогтвортой байдлыг хангасан;
- ✓ Иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан;
- ✓ Санхүү төсвийн зохистой удирдлагаар хангасан;
- ✓ Ил тод байдлыг хангасан;
- ✓ Хариуцлагатай байх;
- ✓ Хэтийн ирээдүй, урт хугацааны бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдсан байх зарчмыг баримтлан Их засаг ОУИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашигласан байна.

Их засаг ОУИС-ийн нийт төсөв нь хөтөлбөр тус бүрээр гаргасан төсвүүдийн нийлбэр байна. Их засаг Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрийн нийт орлогын төсвийг сургалтын орлого, түрээсийн орлого, сургууль хоорондын кредит цагийн хөлс, хандив зэрэг орлогын төрлөөр авч үзвэл,

Орлого		Хичээлийн жил				
		2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Сургалтын төлбөрийн орлого	мян.төг	2,967,950	2,822,800	3,995,300	4,954,400	6,300,100
	Нийт орлогод эзлэх хувь	97.62%	97.62%	97.62%	97.62%	97.62%
Түрээсийн орлого	мян.төг	33,300	33,300	35,100	40,500	40,500
	Нийт орлогод эзлэх хувь	1.10%	1.15%	0.86%	0.80%	0.63%
Сургууль хоорондын кредит цагийн хөлс	мян.төг	38,651	34,354	61,724	79,794	111,384
	нийт орлогод эзлэх хувь	1.27%	1.19%	1.51%	1.57%	1.73%
Хандивын орлого	мян.төг	361	1,121	519	417	1,614
	Нийт орлогод эзлэх хувь	0.01%	0.04%	0.01%	0.01%	0.03%
Нийт орлого	мян.төг	3,040,262	2,891,575	4,092,643	5,075,111	6,453,598
	Нийт орлогод эзлэх хувь	100%	100%	100%	100%	100%

Их засаг Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрийн сүүлийн 5 жилийн зарлагын төсвийн хураангуйг доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт. Эрх зүйн хөтөлбөрийн зардлын хураангуй

мян. төг

Ангилал		Хичээлийн жил				
		2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Цалин хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын зардал, ажилчдад олгох тэтгэмж	мян.төг	944,861	958,416	1,256,451	1,557,853	2,092,804
	Нийт дүнд эзлэх хувь	33.69%	34.20%	34.81%	34.59%	36.10%
Ашиглалтын зардал	мян.төг	446,873	424,066	598,845	740,716	937,951
	Нийт дүнд эзлэх хувь	15.94%	15.13%	16.59%	16.45%	16.18%
Сургалт эрдэм шинжилгээний зардал	мян.төг	103,857	107,802	119,847	162,857	186,291
	Нийт дүнд эзлэх	3.70%	3.85%	3.32%	3.62%	3.21%

	хувь					
Бусад зардал	мян.төг	1,109,827	1,066,753	1,433,307	1,731,930	2,169,550
	Нийт дүнд эзлэх хувь	39.58%	38.06%	39.71%	38.46%	37.42%
Хөрөнгө худалдан авах	мян.төг	198,740	245,700	201,000	310,000	410,619
	Нийт дүнд эзлэх хувь	7.09%	8.77%	5.57%	6.88%	7.08%
Нийт дүн	мян.төг	2,804,157	2,802,737	3,609,451	4,503,357	5,797,214
	Нийт дүнд эзлэх хувь	100%	100%	100%	100%	100%

Цалин хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын зардал, багш ажилчдад олгох буцалтгүй тусламжид зарцуулж буй зардал 35 орчим хувийг эзэлдэг нь хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах, чадавхийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Багшийн хөгжил, сургалт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардалд төсвийн 4 орчим хувийг зарцуулж байгаа нь судалгааны их сургууль болох зорилгод чиглэсэн үйл ажиллагаа болж байна.

Ашиглалтын зардал нийт зардлын 16 орчим хувь, хөрөнгө оруулалт 7 орчим хувийг эзэлж байгаа нь сургалтын орчныг сайжруулах, суралцагчдын тав тухтай байдлыг хангах үндэс болдог байна.

Нэг оюутанд ноогдох өртөг, зардлын тооцоо

Хөтөлбөрийн санхүүжилтийн нэг чухал үзүүлэлт бол нэг оюутанд ногдох өртөг, зардлын тооцоо бөгөөд нийт зардалд үндэслэн хөрөнгө оруулалтыг оруулалгүй авч үзвэл,

Хүснэгт. Эрх зүйн хөтөлбөрийн нэг оюутанд ногдох өртөг, зардал

Хичээлийн жил	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Нэг оюутанд ногдох өртөг, зардал	1772.5	1996.3	1934.3	2127.2	2348.0

Дээрх хүснэгтээс үзэхэд нэг оюутанд ногдох зардал өсөх хандлагатай байсан ч 2016-2017 онд буурч 1934,4 төгрөг болсон нь тухайн хичээлийн жилийн зардал өсөлттэй байхад суралцагчийн тооны өсөлтөөс хамаарч нэг оюутанд ногдох зардал буурсан нь харагдаж байна.

Их Засаг ОУИС-ийн нийт оюутнуудын сургалтын төлбөрийн хэдэн хувь нь “эрх зүй”-н хөтөлбөрт зарцуулагддагийг тооцох нутгийн хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг үнэлж дүгнэхэд ихээхэн ач холбогдолтой байна.

“Эрх зүй”-н хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтийг суралцагчдад цогц боловсрол олгох, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийгддэг дадлагын ажлууд, мэргэжлийн хичээлүүдийн тэмцээн уралдаан, олимпиад, эрдэм шинжилгээний хурал, семинар,

үзэсгэлэн зохион байгуулах, эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа, шинжилгээний ажил туурвих, хэвлүүлэх зэрэг олон хэлбэрээр явуулдаг байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зарцуулсан санхүүжилт нь жил бүр төсөвлөгддөг бөгөөд Их Засаг ОУИС-ийн нийт зардлын 10 орчим хувийг эзэлж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс ном сурах бичгийн хандив, Монголын роял академиас багш нарын сургалтын чанарыг дээшлүүлэх үнэ төлбөргүй сургалт, Грийн ланд групп ХХК-иас багш ажилчид хөнгөлөлттэй үнээр амрах эрх, Монголын роял академиас англи хэлний төлбөргүй сургалт зэрэг олон дэмжлэг бодитойгоор хэрэгжсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Их засаг Хууль зүйн сургуулийн нийт орлогын 97 орчим хувийг сургалтын төлбөрийн орлого эзэлж байгаа нь тухайн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн орлого суралцаж буй оюутны тооноос хамааралтайг харуулж байна. Хөрөнгийн түрээсийн орлого, сургууль хоорондын кредит цагийн төлбөр, хандивын орлого зэрэг бусад орлого нь нийт орлогын 3 орчим хувийг эзэлж байгаа нь цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зөвлөмж:

- Суралцагчдын сурлагын амжилт, эрдэм шинжилгээний ажилд оролцсон байдал зэргийг харгалзан санхүүжилт, урамшууллын тогтолцоог илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх;

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Эрх зүйн хөтөлбөрийг сурталчилах, таниулах үйл ажиллагааг элсэлтийн ерөнхий комисс болон маркетингийн албатай хамтран хэрэгжүүлдэг ажээ.

ИЗХЗС-ийн эрх зүйн хөтөлбөрийг дараах байдлаар сурталчилж, өөрсдийн хийсэн болон хийхээр төлөвлөж буй ажил үйлчилгээгээ олон нийтэд түгээж байна. Тухайлбал, Өөрийн вэб хуудсанд тавих, танилцуулга материал хэвлэж олонд тараах, сургуулийн фэйсбүүк хуудсанд байршуулах, сурталчилгааны телевиз, радиогийн мэдээллээр дамжуулах, кино театрт мэдээлэл цацах, үзэсгэлэн, сургалт боловсролын яармагт оролцож сургууль НББ-ийн хөтөлбөрийн талаархи сурталчилгаа хийх, шилдэг төгсөгчдөд урилга олгох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, нийслэлийн сургуулиудад танилцуулга хийх, ИЗОУИС-иас нийслэлийн ЕБС-ийн төгсөгчдийн дунд "Их сунгаа" боловсролын олимпиад зохион байгуулж, тэргүүлсэн сурагчдад урилга олгодог.

Хөдөө, орон нутагт сүүлийн 5 жил дараалан оюутан элсүүлэх комисс байгуулан, 21 аймагт ажиллаж элсэгчдийн дунд олон төрлийн арга хэмжээ зохиож, сурталчилгаа хийх зэргээр олон арга хэрэгслийг ашиглаж, өөрийн сургуулийн талаар олон нийтийн дунд мэдээлэл түгээж байна.

Хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн тоо жил бүр нэмэгдэж байна.

Их засаг Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг дараах байдлаар сурталчилж, хийхээр төлөвлөж буй ажил үйлчилгээгээ олон нийтэд түгээж байна. Тухайлбал,

- Өөрийн вэб хуудсанд тавих
- Танилцуулга материал хэвлэж олонд тараах
- Сургуулийн фэйсбүүк хуудсанд байршуулах
- Сурталчилгааны телевиз, радиогийн мэдээллээр дамжуулах
- Кино театрт мэдээлэл цацах
- Үзэсгэлэн, сургалт боловсролын яармагт оролцож сургууль НББ-ийн хөтөлбөрийн талаархи сурталчилгаа хийх
- Шилдэг төгсөгчдөд урилга олгох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх
- Нийслэлийн сургуулиудад танилцуулга хийх, Их Засаг ОУИС-иас нийслэлийн ЕБС-ийн төгсөгчдийн дунд “Их сунгаа” боловсролын олимпиад зохион байгуулж тэргүүлсэн сурагчдад урилга олгодог.
- Хөдөө орон нутагт сүүлийн 5 жил дараалан оюутан элсүүлэх комисс байгуулан 21 аймагт ажиллаж элсэгчдийн дунд олон төрлийн арга хэмжээ зохиож, сурталчилгаа хийх зэргээр олон арга хэрэгслийг ашиглаж өөрийн сургуулийн талаар олон нийтийн дунд мэдээлэл түгээж ирсэн байна.
- Сургалтын нэгдсэн албанаас багш, оюутнуудын оролцоотойгоор ИЗОУИС-ийн мэргэжил сурталчлах нээлттэй өдөрлөгийг жил бүр ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд зохион байгуулжээ.
- МИДСК, ХИДСХ-ны шугамаар зохион байгуулагддаг үзэсгэлэн, яармагт оролцох, 2010 оноос TV 8 телевизэд “Эрдмийн түлхүүр” нэртэй 7 хоног тутмын байнгын нэвтрүүлэг, 2009 оноос NTV, UBS, TV-9, 25-р суваг, ТВ-5, Боловсрол телевиз болон Монголын үндэсний радио, Зууны мэдээ, Өдрийн сонин, Үнэн, Үндэсний шуудан сонин, МОНЦАМЭ зэрэг өдөр тутмын сонин хэвлэлд танилцуулга нийтлүүлэх болсон. Зууны мэдээ, Өдрийн сонин, Монголын Үнэн сонинтой байнга хамтран ажиллах гэрээтэй байна.
- Жил бүр “Super student” төслийг ИЗОУИС-ийн салбар сургуулиудын оюутан суралцагчдын дунд 2 үе шаттайгаар 7 дахь жилдээ зохион байгуулсан байна. Тус уралдаанд шалгарсан 20 оюутан хүссэн гадаадын их дээд сургуульдаа 30-40%, 100% тэтгэлгээр 1 жил суралцах эрх, ивээн тэтгэгчдийн шагнал тус тус хүртдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэлтийн үйл ажиллагаа болон сургуулийн сургалтын үйл ажиллагааг тогтмол олон нийтийн мэдээллийн хэрэслээр нийгэмд эерэг хандлагаар сурталчилдаг.

Анхаарах асуудал:

- Багш, оюутан, төгсөгч гэсэн байдлаар эргэх холбоог ашиглан бүрэн хамруулах

Зөвлөмж:

- Туршлага арга барилаа сурталчлах, бусад сургуульд түгээх, туршлага солилцож байх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

Сургалтын хөтөлбөртэй холбоотой асуудлаар оюутнуудаас хичээлийн жилд санал асуулга авч, дүнг сургуулийн удирдлага, оюутнуудад танилцуулах, саналын мөрөөр хийх ажлыг тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгадаг.

Эрх зүйн хөтөлбөрийн багийн багш нар нь мэргэжлийн чиглэлийн ном, сурах бичиг, гарын авлага зэргийг ганцаарчлан болон хамтран туурвиж, сургалтад хэрэглэхийн зэрэгцээ багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг тайлагнуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулан, шалгарсан илтгэлүүдийг эмхэтгэн 2018 онд "Багшийн эрдэм шинжилгээний өгүүлэл-1", 2019 онд " Багшийн эрдэм шинжилгээний өгүүлэл-2" эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлэн гаргах зэрэг ажлуудыг шат дараатай зохион байгуулсан байна.

1998 оноос эхлэн Монголын үндэсний радиотай хамтран "Их Засаг сургуулиар сонин юутай байна", "Мөнх тэнгэрийн хүчин дор" нэвтрүүлгүүдийг давталттайгаар сард 4 удаа тус бүр 20-30 минутын хугацаагаар явуулж, шинээр гарсан хууль сурталчлах, иргэдийн сонирхсон асуултанд хариулахаас гадна сургуулийнхаа эрхэм зорилго, зорилтуудыг сурталчилж байна. Зууны мэдээ, Өдрийн мэдээ сонинд сард 4 удаа Их Засаг ОУИС-ийн тухай мэдээ, мэдээллийг нийтэлж байна.

Сургалтын хөтөлбөрийн холбоотой асуудлаар оюутнуудаас хичээлийн жилд санал асуулга авч, дүнг сургуулийн удирдлага, оюутнуудад танилцуулах, гарсан саналын мөрөөр хийх ажлыг тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгадаг байна.

2005 оноос Их Засаг радио телевизийн студитэй болсон. Мөн Их Засаг ОУИС-ийн дэргэд Рояль 98.9 FM радио, 2011.10.01-ний өдрөөс Рояль HD телевиз байгуулагдсан нь сургуулийн эрхэм зорилго, зорилтууд, сургалт хүмүүжлийн олон талт үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах өргөн боломжийг олгож байна.

2018 онд багш Б.Батзориг, Л.Эрдэнэхүү нарын санаачилагаар ИЗХЗС-ийн дэргэд "IZIU-TV" бичил телевизийг байгуулан 1-3 дугаар курсын 13 оюутан, 2 багшийн хамт баг болон ажиллаж байна. Энэ телевизийн гол зорилго нь эрх зүйн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад зориулсан мэдээ мэдээллийг хүргэх, хөтөлбөрийн багаас хийж гүйцэтгэж буй ажлыг бусдад таниулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Ажлын арга барил, үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгоход байнга анхаарч ажиллах

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь БШУ-ны сайдын 2014 оны А/174 тушаалд нийцүүлэн Эрх зүйн бакалаврын боловсролын хөтөлбөрөөр суралцагсдыг ИЗОУИС-д оюутан элсүүлэх журам, Элсэгчдэд танилцуулга хийх журам, Элсэгчдийг бүртгэх журам зэргийг баримтлан элсэлтийг Улаанбаатар хот, 21 аймагт элсэлтийн салбар комисс ажиллуулан ЕБДС төгсөгчдийн математик, нийгмийн тухай мэдлэг, монгол хэлний элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харгалзан элсүүлдэг байна.
- Сүүлийн 5 жилд 3220 сурагч элсүүлсэн ба энэ нь элсэхээр хүсэлт гаргасан нийт 3882 сурагчийн 82 хувийг эзэлж байгаа ба элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо 508 байна.
- Элсэгчдэд зориулсан мэдээллийг сургуулийн веб хуудас, фэйсбүүкээр болон ТВ, сошиал мэдээллийн сувгуудыг ашиглахын зэрэгцээ сургуулийн танилцуулга, тараах материалыг олон нийтэд тараах замаар хүргэдэг. Мөн ЕБДС-ийн сурагчдын дунд „Их сунгаа” олимпиад зохион байгуулж шалгарсан сурагчдад урилга олгох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо 508 байгаа нь БСШУСЯ-наас тогтоосон босго онооноос нилээд дээгүүр байгаа нь ололттой тал юм.
- ИЗОУИС-ийн дэргэд Малчин ТВ, ROYAL ТВ, SEVEN ТВ зэрэг мэдээллийн сүлжээг ашиглан элсэгчдэд шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх, сургуулийн танилцуулга, сурталчилгаа хийх давуу талтай

Анхаарах асуудал:

- Жил бүрийн элсэгчдийн тоог төлөвлөхдөө зөвхөн ЕБДС төгсөгчдийн тоог харгалзах бус багшлах боловсон хүчний нөөц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзах

Зөвлөмж:

- Эрх зүй хөтөлбөрийн элсэгчдийн тоог оновчтой төлөвлөх урт хугацааны /прогноз/ урьдчилсан төлөвлөлт хийснээр багшлах бүрэлдэхүүний нөөцийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулах, эрсдлийг урьдчилан тооцоход анхаарах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагсдад үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээтэй холбоотой арга хэмжээг хичээлийн жилийн нэгдсэн график төлөвлөгөөнд тусгахын зэрэгцээ салбар сургуулийн удирдлагын баг, курс хариуцсан багш, чиглүүлэгч багш, дотуур байрны багш, сургуулийн эмч өөрсдийн хариуцсан ажлын чиглэлээр тодорхой ажлууд төлөвлөн хэрэгжүүлж тайлагнадаг.

- Суралцагсдад Цогц боловсрол олгох хөтөлбөр, Амжилт ахиулах хөтөлбөр, насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид чиглэсэн зөвлөн туслах тусгай хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж хэвшжээ.
- Багш бүр 7 хоног бүрийн Лхагва, Пүрэв гаригийг оюутантай ажиллах өдөр болгон оюутанд зөвлөж, тусладаг байна.
- Суралцагсдаас улирал тутам сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны мөрөөр тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ирсэн нь өөрийн үнэлгээний тайлан болон бусад нотлох баримтуудаар нотлогдож байна.
- Оюутны хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой нэршилтэй буюу нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлуудыг үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулах, шилдэг илтгэл, реферат, эссэ бичлэг, өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл шалгаруулж, мэргэжлийн хичээлээр олимпиад зохион байгуулдаг ажлыг тогтмолжуулжээ. Тус сургуулийн суралцагчид Улсын хэмжээнд зохион байгуулагддаг шүүхийн мэтгэлцээний МОСКTRAIL тэмцээнд жил бүр амжилттай оролцож шагналт байруудыг эзэлж иржээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад зориулсан суралцах арга барилд сургах, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах ,аливаа ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, амьдралын зөв хэвшил төлөвшүүлэхэд зөвлөн туслах тусгай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлдэг нь онцлог бөгөөд сайн туршлага болно.

Зөвлөмж:

- Нэгэнт хэвшил болгосон зөвлөн туслах арга хэмжээнүүдээ улам чанаржуулан суралцагсдын эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ болон шинэлэг арга хэмжээг санаачлан зохион байгуулдаг байх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнуудын үүсгэл санаачлагын FACT шүүхийн мэтгэлцээний клуб, LAWEYR WOMEN охидын клуб, OPEN MAID клуб, Залуу судлаач клуб, Оюутан парламент, Охид манлайлагч клуб зэрэг мэргэжлийн чиглэлийн сайн дурын байгууллага, мөн Оюутны нутгийн зөвлөл, Малчдын алдар холбоо, Ураг удмын холбоо, Төгсөгчдийн холбоо зэрэг оюутны олон нийтийн байгууллагыг сургуулийн захиргаа дэмжин ажилладаг.
- Оюутнуудын сургалт, эрдэм шинжилгээ, урлаг спортод гаргасан амжилт, олон нийтийн ажилд оролцсон идэвхи оролцоог харгалзан нэмэлт оноо өгөх, сургалтын төлбөрийг 10-100 хувь хөнгөлөх урамшуулал эдлүүлдэг. Түүнчлэн өнчин суралцагч, 1 айлын 2 хүүхдийн, гэр бүлийн, багш ажилчдын хүүхдийн сургалтын төлбөрийг 10-

20 хувь хөнгөлдөг байна. Сүүлийн 5 жилд 271 оюутанд 78.999.000 төгрөгийн хөнгөлөлт, урамшуулал эдлүүлжээ.

- Сургуулийн захиргаа сүүлийн 5 жилийн хугацаанд 271 оюутныг цагийн ажилд, 211 төгсөгчийг үндсэн ажлын байранд зуучилсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны сурах идэвхи санаачлагыг хөхүүлэн дэмжих, авьяас чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амьдрал ахуйд туслалцаа үзүүлэх чиглэлээр 14 төрлийн хөнгөлөлт, урамшуулал эдлүүлдэг нь онцлог болно.
- Суралцагчдынхаа олсон амжилтыг олон нийтэд сурталчлах, тэдгээрийг алдаршуулах ажлыг ТВ болон бусад сошиал орчин, сургуулийн дотоод мэдээллийн сүлжээг тогтмол ашиглаж байгаа нь давуу тал юм.

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын үүсгэл санаачлагын олон байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, чанарын асуудалд анхаарч тоон үзүүлэлтийг голлох бус оюутанд хүрэх үр дүнг харгалзан дэмжиж ажиллах.

Зөвлөмж:

- Оюутны мэргэжлийн клубуудын ажлыг тогтмолжуулж, үйл ажиллагааг чанаржуулахын зэрэгцээ оюутны хамрах хүрээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг сүүлийн 2 жилээр гаргасан байна. 2018-2019 оны хичээлийн жилд 1012 суралцагч элссэн бол 2019-2020 онд 859 суралцагч 2-р ангидаа дэвшин суралцсан бөгөөд 153 оюутан шилжилт хөдөлгөөн хийжээ. Эдгээрээс 33 оюутан гадаадын их дээд сургуульд, 12 оюутан цэргийн албанд, 37 оюутан эрүүл мэндийн шалтгаанаар, 19 оюутан төлбөрийн шалтгаанаар, 13 оюутан хөтөлбөрөө сольж, 38 оюутан кредит хангаагүй, ар гэрийн гачигдал, өөрийн хүсэлтээр зэрэг шалтгаантай байсан байна.
- ИЗОУИС-ийн ректорын 2019 оны 12-р сарын 11-ний өдрийн 1 дүгээр тушаалын 5-р хавсралтаар шинэчлэн баталсан "Оюутан шилжүүлэн суралцуулах журам"-ын дөрөвдүгээр бүлгээр багц цаг шилжүүлэн тооцох журмыг зохицуулсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан дүрэм, журмыг багш, суралцагчдад танилцах боломжоор хангасан байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөний шалтгаан, нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийн талаар дүн шинжилгээ хийдэг байх.

Зөвлөмж:

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөний шалтгаан нөхцөл, гадаад дотоод хүчин зүйлийн талаар дүн шинжилгээ хийснээр хөтөлбөрийн чанар, үр нөлөөг сайжруулах ойрын болон хэтийн төлөвлөлтийг хийхэд харгалзах үзүүлэлт болгоход анхаарах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон зохих шатны боловсролын агуулга эзэмшсэн болохыг гэрчилсэн төгсөлтийн баримт бичгийг олгохдоо Ректорын 2015 оны 11 дүгээр сарын 11- ний өдрийн А/187 дугаар тушаалаар баталсан ИЗОУИС-ийн сургалтын журмын 4.11.3 –д заасныг мөрддөг байна.
- Тухайн хөтөлбөрөөр эзэмшвэл зохих хичээлүүдийн кредитийг хангаж, төгсөлтийн шалгалтаа амжилттай өгсөн төгсөгчдөд Төгсөлтийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн гаргасан ИЗОУИС-ийн ректорын тушаалаар Эрх зүйн бакалаврын зэргийн диплом олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар, агуулга нь холбогдох дүрэм журамд нийцсэн байна.

Зөвлөмж:

- Төгсөлтийн баримт бичиг олгох, холбогдох баримт бичгийг хадгалах, архивын нэгж болгох зэрэг үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг цаг тухайд нь боловронгуй болгон мөрдөж ажиллах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль нь 2009 онд Их засаг Их сургуулийг 2009-2019 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө баталж, 2019 онд Ректорын А/121 дугаар тушаалаар тус сургуулийг 2019-2025 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг өөрчлөн баталсан бөгөөд уг төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогоо тодорхойлсон байна.
- Эрх зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцдог нийт 83 багшийн 11 нь доктор /Ph.D/, 19 нь докторант байгаа бөгөөд 5 докторант урьдчилсан хамгаалалтад орсон ба 2020 оны намар жинхэнэ хамгаалалтанд орох гэж байна. Мөн мэргэжлийн байгууллагуудад он удаан жил ажиллаж байсан онол дадлагыг өндөр түвшинд эзэмшсэн мэргэжлийн туршлага бүхий 10 орчим ахмад багш ажиллаж байна.
- Багш нар 1-3 хичээл заадаг бөгөөд 7 хоногийн ажлын ачаалал нь 16 академик цагаас хэтэрдэггүй бөгөөд 1 багшид дунджаар 28 оюутан ноогдох харьцаатай байна.
- Багшийн эрдэм шинжилгээ судалгааны ажилд сүүлийн 3 жилд 331,9 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон ба багшийн хөгжлийг дэмжихэд 142,8 сая төгрөг зарцуулсан байна

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн захиргаа багш нарын эрдэм шинжилгээний ажилд болон мэргэжил дээшлүүлэх, ахисан түвшинд суралцах, ном сурах бичиг хэвлүүлэх зэрэгт урамшуулал хөнгөлөлт эдлүүлэхийн зэрэгцээ ажлын үр дүнг харгалзан зэрэглэл ахиулах, мөнгөн урамшуулал үзүүлэх, хүүхдийнх нь цэцэрлэг, сургуулийн төлбөрт хөнгөлөлт үзүүлдэг байна.

Анхаарах асуудал:

- Эрдмийн зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Докторант багш нарын судалгааны ажлыг эрчимжүүлж, хугацаанд нь хамгаалуулахад хяналт тавьж, тодорхой хөшүүрэг хэрэглэх.
- Багшийн үнэлгээг кредит тогтолцоонд бүрэн шилжүүлэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн багш бүр багшийн хөгжлийн дэвтэр хөтөлдөг бөгөөд жил бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөгөө сургуулийн захирлаар батлуулж, жилийн эцэст өөрийн үнэлгээний тайлан бичиж удирдлагын багт хамгаалдаг байна.
- Сүүлийн 5 жилд 3 багш докторын зэрэг хамгаалж, 58 багш дотооддоо, 41 багш гадаадад мэргэжил дээшлүүлсэн ба багшийн туслах 14 хүн магистрийн зэрэг хамгаалж нийт 116 хүн мэргэжил ур чадвараа дээшлүүлжээ.
- ИЗОУИС-ийн ректорын тушаалаар батлагдсан Багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам, Багшийн албан тушаалын зэрэглэлийн шалгуур үзүүлэлт, Багш,

ажилчдын хөгжлийг дэмжих журам зэрэг эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Бүх багш багшийн хөгжлийн дэвтэр, багшийн хавтас хөтөлж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Багш хөгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, багш бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагыг харгалзан багшийн хөгжлийг төлөвлөдөг байх.

Зөвлөмж:

- Сургуулийн захиргаа багшийн хөгжлийг жил жилээр төлөвлөдөг боловч хөгжлийн чиглэл бүрээр багш бүрийг хөгжүүлэх урт, богино хугацааны төлөвлөгөө /прогноз/ боловсруулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилладаг байх.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн ректорын “Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны А/61 тушаал, мөн тушаалын хавсралтаар батлагдсан ИЗОУИС-ийн эрдэм шинжилгээний их семинар зохион байгуулах журам зэргийг мөрдөн ажилладаг.
- Сүүлийн 5 жилд 83 багш нийт 82 ном, сурах бичиг зохиож, 112 өгүүлэл нийтлүүлж, 205 илтгэл хэлэлцүүлсэн ба 21 бүтээлд зохиогчийн эрхийн гэрчилгээ авчээ.
- Сүүлийн 3 жилд үндэсний болон олон улсын хэмжээний бага хурал зохион байгуулж нийт 77,8 сая төгрөг зарцуулсан байна.
- Жил бүр шилдэг судлаач багш шалгаруулдаг уламжлалтай бөгөөд үндэсний болон олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний нэрэмжит бага хурлуудыг тогтмол зохион байгуулж хэвшүүлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын бичсэн ном, сурах бичгийн хэвлэлийн зардлыг сургууль дааж хэвлүүлдэг.
- Багш нарыг гадаад дотоод докторантурт суралцах төлбөр болон бусад зардлыг тодорхой хувиар сургуулийн захиргаа хариуцдаг нь багш нарын эрдэм судлалын ажлыг дэмжихэд бодитой хувь нэмэр болж байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын эрдэм судлалын ажлын цар хүрээг өргөжүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Багш нарыг судалгааны төсөл, хөтөлбөр, захиалгат буюу гэрээт эрдэм шинжилгээ судалгааны ажилд хамруулах талаар санаачлагатай ажиллах.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан Багшийн ажлын үнэлгээний журмыг мөрдөж ажилладаг. Багш бүрийн жилийн ажлын болон багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөөг сургуулийн захирал баталж, жилийн эцэст өөрийн үнэлгээ хийлгэдэг ба суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч хөндлөнгийн үнэлгээ хийлгэн удирдлагын багаар хэлэлцүүлэн үнэлүүлдэг байна.
- Багшийн ажлын үнэлгээний дүнг харгалзан багшийн цалин дээр нэмэгдэл урамшуулал олгох, албан тушаалын зэрэглэл ахиулах, зэрэглэл бууруулах, ажлаас чөлөөлөх арга хэмжээ авдаг.
- Багш нарыг 2 жил тутам аттестатчилдаг нь багшийн ажлыг үнэлэх бас нэгэн хэлбэр болдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг жил бүр хийж өөрийн үнэлгээний тайлан хамгаалж, хэвшил болгосон нь багшийн хөгжлийн дэвтрээс харагдана.

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа цогц хөгжлийн шалгуурыг тодорхой болгон гүйцэтгэлийг нь үнэлдэг байх.

Зөвлөмж:

- Багшийн ажлыг үнэлэхдээ багш бүрийн онцлогт тохирсон, өөрийгөө хөгжүүлэхэд гаргасан ахиц дэвшлийн үзүүлэлтийг түлхүү харгалздаг байх.
- Багшийг аттестатчилах хугацааг багшийн албан тушаалын шатлал харгалзан оновчтой тогтоох

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь Чанарын баталгаажуулалтын гарын авлагыг 2019 онд хэвлүүлэн сургуулийн нэгжүүдийн удирдлага болон багш, ажилтнуудад тараасан байна. Ректорын 2019 оны 9-р сарын 23- ны өдрийн А/80 дугаар тушаалаар ИЗОУИС-ийн чанарын баталгаажуулалтын албаны ажиллах дүрэм, Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх журам зэргийг баталжээ.
- Тус сургууль нь чанарын баталгаажуулалтын нэгжийг Сургалт эрхэлсэн проректорын дэргэд байгуулан чанарын менежментийн системийг бүрдүүлж, Удирдлагын мэдээллийн системийн UNIMIS-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
- ИЗОУИС нь хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт хийх үйл ажиллагааг орц-үйл явц-гарц-үрдүн-үр нөлөөг цогц байдлаар үнэлгээ хийхэд чиглүүлсэн ба хичээлийн хөтөлбөрүүдээ бүгдийг шинэчилжээ.
- 2019-2023 оны хичээлийн жилийн чанарын баталгаажуулалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг нэвтрүүлсэн

Анхаарахасуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлаа эрчимжүүлэх.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын удирдлагын тогтолцоогоо бүхий л үзүүлэлтээр Олон улсын стандартын түвшинд хүргэхэд анхаарч ажиллах,

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийг нийт 6539 төгсөгч төгссөн ба тэдгээрийн 298 нь шүүхийн, 893 нь цагдаагийн, 295 нь прокурорын, 85 нь нотариатын, 291 нь ШШГ, 550 нь өмгөөллийн, 650 нь төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа бөгөөд 112 нь багш, 350 нь хуулийн зөвлөх, 52 нь тагнуулын ерөнхий газар, 16 нь Авилгатай тэмцэх газар мөн 831 нь мэргэжлийн чиглэлээрээ тус тус ажиллаж байгаа нь нийт төгсөгчдийн 67.6 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь мэргэжлийн салбарт сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг зохих түвшинд хангаж байна гэж үзэхээр байна.
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг сүүлийн 3 жилээр авч үзвэл 11 төгсөгч шүүгчээр, 25 төгсөгч прокуророор томилогдсон ба 150 төгсөгч өмгөөлөгчийн эрхтэй болж өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байна.

- Суралцагч, төгсөгч, ажил олгогч нараас авсан сэтгэл ханамжийн судалгаа, сонирхлын бүлгүүдийн тлөөлөлтэй хийсэ уулзалтын дүнгээс харахад ИЗОУИС-ийн суралцагчдын хувьд тус сургуулийн талаар олон сувгаар мэдээлэл олж авсан, олон нийтэд нэр хүндтэй, материалаг бааз сайтай, дүрэмт хувцас өмсдөг, цогц хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг, багш нар чадвартай, байраар хангадаг, 7 хоногийн 1 өдрийг бие даалтын өдөр болгож багш нар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг, төгсөгчдийн хувьд ИЗОУИС нь нийгэмд танигдсан нэр хүндтэй учир ажилд ороход нөлөөлдөг, сургалтын материалаг бааз сайтай, цогц боловсролыг үр дүнтэй өгдөг учир ирээдүйн амьдралд бэлтгэгдсэн, ажил олгогчдын хувьд тус сургуулийг төгсөгчдийн ачаалал даах, багаар ажиллах чадвар сайн, гүйцэтгэлийн хариуцлага илүү, харилцааны соёл сайтай, компьютер, гадаад хэл, урлаг, спортын авъяастай, зохион байгуулах, санаачлагатай ажиллах чадвартай гэж үнэлсэн байна.
- Дотоод хяналт шалгалт хийх, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, багш нарын Ажлын гүйцэтгэлийг үнэлэх баг /АГҮБ/ нь сар тутамд ажиллаж, үр дүнг тогтмол тайлагнадаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн мэргэжлийн ажил эрхлэлтийн хувь өндөр байгаа нь суралцагчдад цогц боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг нэг гол үзүүлэлт болж байна.

Анхаарах асуудал:

Практик сургалтын цагийг нэмэгдүүлэх шаардлагатай талаар төгсөгчдөөс авсан судалгаанд дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулж, тэднийг ахисан түвшинд болон давтан сургалтанд хамруулах ажлыг төлөвлөгөөтэй зохиох байгуулж байх.
- Сонирхлын бүлгүүдээс авдаг сэтгэл ханамжийн судалгааг хөтөлбөрийг боловсронгуй болгох хэрэгсэл болгон ашигладаг байх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь 2014, 2017 онуудад Их Британий Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл /BAC/-өөр магадлан итгэмжлүүлж Олон улсад магадлан итгэмжлэгдсэн.
- Олон улсын CSIC судалгааны байгууллагаас дэлхийн шилдэг их дээд сургуулийг эрэмбэлсэн чансаанд Монгол Улсаас эрэмблэгдсэн 24 их сургуулийн 14 дэх нь ИЗОУИС болсон .
- Үндэсний хэмжээнд Монгол Улсын ТОП 5 сургуулийн нэг, Оюутанд ээлтэй сургуулиар 3 удаа шалгарсан, ГРАНД ЭКСПО, BEST OF MONGOLIA үндэсний хэмжээний шалгаруулалтанд 2 жил дараалан шилдгийн шилдэг сургуулиар шалгарч байжээ.

- Чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн зэрэг нь Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх үндэс суурь болж байна гэж сургуулийн хамт олон үнэлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус их сургууль нь байгууллагын хувьд олон улсад магадлан итгэмжлэгдсэн нь эрх зүйн хөтөлбөрөөр элсэгчид, суралцагчид, төгсөгчдийн хувьд бахархал болох чухал үзүүлэлт юм.

Анхаарах асуудал:

- Эрх зүй хөтөлбөрөөр суралцагчдад Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх цргц чадамжийг олгоход анхаарах.

Зөвлөмж:

- Эрх зүй хөтөлбөрөө олон улсын жишигт хүргэхэд чиглүүлэн тогтмол боловсронгуй болгон чанарын баталгаажуулалтыг дотооддоо төдийгүй олон улсын хэмжээнд хийлгэхэд хөтөлбөрийн зорилго зорилтоо чиглүүлэх.

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: **БҮРЭН ХАНГАСАН**

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Хангаагүй үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2 Сургалтынүйлажиллагаа	2			
3 Хөтөлбөрхэрэгжүүлэхорчин, технологийннөхцөл	2			
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6 Багшийн үйл ажиллагаа	2			
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Нэгдсэн дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, суралцагчид, төгсөгчид, ажил олгогчид, багш ажилтнуудтай хийсэн уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Их Засаг Олон улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрх зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч

Ц.Мөнхбат

Шинжээчийн багийн гишүүн

Д. Наранчимэг

Шинжээчийн багийн гишүүн

Б.Улаанбаатар

IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

Оюутны төлөөлөл

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Имэйл хаяг
1	Б.Баттулга	IV	Орон нутаг	99411511	babuoyuka07252gmail.com
2	Б.Золбоо		Оюутан үйлчилгээний төв	94841192	zolboo487@gmail.com
3	Т.Уянга		Улаанбаатар	88838484	uyanga0happy@gmail.com
4	С.Шинэсар		Эрдэм шинжилгээ	89994879	shinesarsiilegmaa@gmail.com
5	Т.Сумьяабазар		Клиник сургалтын төв	86696133	T.sumyabazar12345@gmail.com
6	М.Батбаатар		Клиник сургалтын төв	99833783	batbaatarmonhdoo@gmail.com
7	Б.Батсуурь		Спорт	85858177	seek5213@gmail.com
8	Т.Оюуншүр	III	Хөдөө орон нутаг	94784180	Shvree065@gmail.com
9	У.Батсуурь		Орон нутаг	80817290	u.batsuurii0405@gmail.com
10	Ж.Цагаандарь		Дадлага	Япон улс	tjunraijamts@gmail.com
11	Я.Бадмаараг		Дадлага	Япон улс	badmaarag74@yahoo.com
12	Э.Батчөдөр		Супер студент	АНУ	B_chodroo@yahoo.com
13	М.Сугармаа	II	Хөгжлийн бэрхшээлтэй	89810119	Suragmaa.M@gmail.com
14	Ууганбаяр		Оюутны байр	89154168	uuganaajoshua@gmail.com
15	Д.Отгонбаяр		Орон нутаг	90303099	dansranotgonbaatar@gmail.com
16	М.Сарангарав		Орон нутаг	94641480	sarangarav.monkhubayr@gmail.com
17	О.Мөнхзаяа		Орон нутаг	90770055	Munkhzaya0409@gmail.com
18	Э.Дэлгэрзаяа	I	Орон нутаг	80890825	Delgerzaya.elbegzaya@gmail.com
19	Ц.Мөнхцэцэг		ЭЕШ	86863546	tserendashmonkhtsetseg1105@gmail.com
20	Б.Моломжамц		ЭЕШ	89961216	bmolomjamts38@gmail.com

Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Имэйл хаяг
1	Ц.Мөнхбат	MN-ХХК	88106589	Munkhbatmuugii@gmail.com
2	Н.Наранбаяр	ХНН	99115852	naranbayar55@gmail.com
3	Н.Батгэрэл	Төрийн банк активын газар	99030191	N.batgerel@yahoo.com
4	Д.Цэцэгдарь	МХХ	99001130	Tsetsedari1130@gmail.com
5	Н.Болортулга	Брови айс ХХК	99110978	Bolortulgatulгаа@yahoo.com
6	Н.Гэрэлтуяа	БЗД, СБД, ЧД- ЭХАШШүүх	86050515	gereltuya880226@gmail.com
7	Б.Баттөмөр	ХНН	88117684	Bbt.advo@gmail.com
8	С.Баярцэцэг	MN-MBM холдинг хүний нөөц	89005749	Bayaraa0818@gmail.com
9	А.Хулан	МХХ	99461122	hulanlucy@gmail.com
10	Б.Бээжин	БГД, ХУД, СХД - ТГД	99072851	
11	Д.Цэцэгдарь	ХЗҮХ	99001130	tsetsegdariaa@gmail.com

Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Имэйл хаяг
1	Б.Батзаяа	2004	ИЗТХ ерхөнхийлөгч	99111883	zayalawzoloo@gmail.com
2	Ч.Атарболд	2014	Өмгөөлөгч	88118666	Atar4417@gmail.com
3	Г.Лхагвасүрэн	2014	Өмгөөлөгч	99092918	Lhagvaalha15@gmail.com
4	Н.Түвшинзаяа	2017	Өмгөөлөгч	95119082	Tvwshinzayanaa@yahoo.com
5	К.Отгонцэцэг	2017	Өмгөөлөгч	88688506	oogii8370@gmail.com
6	Б.Түвшинтөгс	2017	Өмгөөлөгч	95265352	batbayr4999@yahoo.com
7	М.Дорждамба	2019	УИХ гишүүн туслах	89992777	Dambaa_34@gmail.com
8	Т.Буян-Аривжих	2019	ХУД-ИХАШШ	88249020	Aajii0902@gmail.com
9	Н.Энхтөр	2018	НП про туслах	99221123	Enhtur0927@gmail.com
10	А.Бямбасүрэн	2018	Хуулийн зөвлөх	88246211	bbyambaa233@gmail.com
11	А.Эрдэнэтулга	2018	Хуулийн зөвлөх	94002047	a.erdenetulga0326@gmail.com
12	О.Батсайхан	2012	БОАЖЯ-ны хуулийн мэргэжилтэн	88228009	Obatkhaan@gmail.com
13	О.Буянтөр	2017	Хуулийн зөвлөх	99333939	Buyka99.buyka@gmail.com
14	Т.Анхцэцэг	2015	Өмгөөлөгч	88111239	ankhaaakhaa05@yahoo.com
15	Б.Билгүүн	2017	Хувиараа ажил эрхлэгч	88117010	Bilguunbayrsaikhan@yahoo.com

Ү. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийнхуралдаан(огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж/Recommendations/

✓

ҮІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
.....[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн
дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж/Recommendations/

✓